ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өмнөговь аймгийн Цогтцэций сумын 27 дугаар цэцэрлэгийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ӨМА-2026/064/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.Umnugovi@audit.mn<br>Өмнөговь аймаг<br><br>2026 он | Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр<br>Утас: 70533539 Цахим хаяг: usukhbayarts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Т.Хонгорзул<br>Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Г.Шижирболд<br>Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn<br>Аудитор: Ө.Болортуяа<br>Утас: 70533552 Цахим хаяг: Bolortuyau@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 9
5.1 Төлбөрийн акт ..... 9
5.1 Албан шаардлага ..... 10
5.2 Зөвлөмж ..... 10
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 12

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2026.02.11 № 49

танай ______________-ны №______________ -т

ЦОГТЦЭЦИЙ СУМЫН 27 ДУГААР
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Э.САЙНБУЯН ТАНАА

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цогтцэций сумын 27 дугаар цэцэрлэгийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Дараах зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Үүнд:

- Албан хаагчдад илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас хөтлөөгүй, байгууллагын даргын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй,
- Ээлжийн амралтын олговрыг олгохдоо мэдэгдэл, ээлжийн амралтын олговор бодсон хуудас хөтлөөгүй,
- Завсрын аудитаар илэрсэн хүнсний материал дутагдуулсан, тайлан буруу тайлагнасан зөрчилд зөвлөмжийг хэрэгжүүлээгүй хүнсний тайлангийн 22,834,2 мянган төгрөгийн орлогын баримт, 644,5 мянган төгрөгийн зарлагын баримт дутуу байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.1, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын

F:\2.Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

гуравдугаар бүлгийн 1, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.3 дахь хэсэгтэй нийцээгүй, санхүүгийн тайлангийн үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Цогтцэций сумын хэмжээнд хэрэгжүүлсэн "Шинэ 1000 айл" хөтөлбөрийн хүрээнд байгууллагын 5 албан хаагчийг дэмжлэгт хамруулан амьдрах нөхцөлийг сайжруулсан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Орон нутгийн төсвөөс 114,587.6 мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл, 141,547.0 мянган төгрөгийн "Нутгийн дэм" урамшуулал, 37,038.2 мянган төгрөгийн хүүхдийн хоолны нэмэгдэл, 93,065.6 мянган төгрөгийн тогтмол зардлын санхүүжилт олгосон байна.

**Бусад асуудал хэсэг**

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 42 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг 94.6 хувийн гүйцэтгэлтэй дүгнүүлсэн байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

F:\2.Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ӨСӨХБАЯР

F:\2.Бичиг хэрэг\2026он\СТА-н дүгнэлт\Төсөл.Docx

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 299,742,586.99 | 177,779,528.37 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 210,311,701.22 | 42,269,738.37 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 210,311,701.22 | 42,269,738.37 |
| 3121 | Төгрөг | 210,311,701.22 | 42,269,738.37 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 210,311,701.22 | 42,269,738.37 |
| 33 | АВЛАГА | 284,832.07 | 00.00 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 284,832.07 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 89,146,053.70 | 135,509,790.00 |
| 351 | Түүхий эд материал | 81,731,438.00 | 124,694,990.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 81,731,438.00 | 124,694,990.00 |
| 354 | Хангамжийн материал | 7,414,615.70 | 5,839,800.00 |
| 35460 | Хүнсний материал | 6,164,615.70 | 4,589,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 1,250,000.00 | 1,250,000.00 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 00.00 | 4,975,000.00 |
| 36100 | Барааны нөөц | 00.00 | 4,975,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,951,989,339.52 | 1,822,067,795.53 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,951,989,339.52 | 1,822,067,795.53 |
| 392 | Биет хөрөнгө | 1,855,920,589.56 | 1,726,017,795.53 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,853,034,584.00 | 1,853,034,584.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -250,716,979.08 | -305,566,242.60 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 156,150,373.00 | 153,490,473.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -48,343,200.03 | -87,869,024.28 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 96,716,643.69 | 95,926,643.69 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -48,280,950.38 | -61,468,211.74 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 44,614,700.00 | 44,614,700.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -4,942,548.24 | -6,398,626.56 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 80,889,000.00 | 80,889,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -23,756,333.40 | -41,190,799.98 |
| 39217 | Ном | 555,300.00 | 555,300.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 96,068,749.96 | 96,050,000.00 |
| 39301 | Програм хангамж | 137,500.00 | 50,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -68,750.04 | 00.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 96,000,000.00 | 96,000,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 2,251,731,926.51 | 1,999,847,323.90 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 7,620,789.69 | 6,230,746.35 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 7,620,789.69 | 6,230,746.35 |
| 413 | Өглөг | 7,620,789.69 | 6,230,746.35 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 2,217,454,247.91 | 1,966,959,688.64 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 2,217,454,247.91 | 1,966,959,688.64 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 2,217,454,247.91 | 1,966,959,688.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,032,412,500.56 | 2,217,454,247.91 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 185,041,747.35 | (250,494,559.27) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 2,225,075,037.60 | 1,973,190,434.99 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан*

/төгрөгөөр/

| код | Үзүүлэлт | Өмнөх оны үзүүлэлт | Тайлант оны үзүүлэлт |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 1,502,923,096.50 | 1,336,773,981.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 436,660,296.50 | 1,336,773,981.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 436,660,296.50 | 349,862,881.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 236,942,346.00 | 293,457,881.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 236,942,346.00 | 293,457,881.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 179,002,050.50 | 1,630,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 20,715,900.00 | 54,775,000.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 986,911,100.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 986,911,100.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 986,911,100.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | - | 986,911,100.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,066,262,800.00 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,066,262,800.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,066,262,800.00 | - |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 1,317,881,349.15 | 1,587,268,540.27 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,317,881,349.15 | 1,587,268,540.27 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,280,405,349.15 | 1,587,268,540.27 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 857,617,743.64 | 1,135,684,404.95 |
| 210101 | Үндсэн цалин | 732,920,467.29 | 724,882,641.53 |
| 210102 | Нэмэгдэл | 124,697,276.35 | 399,809,463.42 |
| 210104 | Урамшуулал | - | 10,992,300.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 107,027,613.34 | 137,793,272.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 68,595,332.79 | 93,908,086.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 8,546,208.08 | 10,974,096.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 7,483,928.63 | 5,488,348.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 2,962,074.12 | 5,488,348.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 19,440,069.72 | 21,934,393.12 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 22,504,947.01 | 4,748,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 195,000.00 | 4,748,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 757,296.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 21,552,651.01 | - |
| 2105 | Нормативт зардал | 153,090,969.51 | 138,321,170.50 |
| 210502 | Хоол, хүнс | 153,090,969.51 | 138,321,170.50 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,373,900.00 | 1,093,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,373,900.00 | 1,093,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 136,790,175.65 | 169,628,191.99 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,212,851.00 | 38,076,648.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 66,000.00 | - |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 112,511,324.65 | 131,551,543.99 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 37,476,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 37,476,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 37,476,000.00 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 185,041,747.35 | (250,494,559.27) |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 185,041,747.35 | (250,494,559.27) |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

*Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| код | Үзүүлэлт | Өмнөх оны үзүүлэлт | Тайлант оны үзүүлэлт |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 1,303,205,146.00 | 1,280,653,813.07 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 236,942,346.00 | 1,280,653,813.07 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 236,942,346.00 | 293,742,713.07 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 236,942,346.00 | 293,742,713.07 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 284,832.07 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 236,942,346.00 | 293,457,881.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 986,911,100.00 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 986,911,100.00 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 986,911,100.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого\\ | - | 986,911,100.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,066,262,800.00 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 1,066,262,800.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,066,262,800.00 | - |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,189,086,294.29 | 1,448,695,775.92 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,189,086,294.29 | 1,448,695,775.92 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,151,628,294.29 | 1,448,695,775.92 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 841,169,138.48 | 1,137,074,448.29 |
| 210101 | Үндсэн цалин | 532,235,221.14 | 727,941,384.45 |
| 210102 | Нэмэгдэл | 288,221,167.34 | 398,140,763.84 |
| 210104 | Урамшуулал | 20,712,750.00 | 10,992,300.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 115,895,428.81 | 137,793,272.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 81,641,428.81 | 93,908,086.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 8,563,500.00 | 10,974,096.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 4,281,800.00 | 5,488,348.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 4,281,800.00 | 5,488,348.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 17,126,900.00 | 21,934,393.12 |
| 2105 | Нормативт зардал | 151,364,008.00 | 136,746,354.80 |
| 210502 | Хоол, хүнс | 151,364,008.00 | 136,746,354.80 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,373,900.00 | 4,162,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 3,373,900.00 | 4,162,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 39,825,819.00 | 32,919,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,242,519.00 | 23,393,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,583,300.00 | 9,526,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 37,458,000.00 | - |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 37,458,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 37,458,000.00 | - |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 114,118,851.71 | (168,041,962.85) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 114,118,851.71 | (168,041,962.85) |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 96,192,849.51 | 210,311,701.22 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 210,311,701.22 | 42,269,738.37 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

*Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| код | Дансны нэр, төрөл | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | 2,032,412,500.56 | 2,032,412,500.56 |
| 2 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 2,032,412,500.56 | 2,032,412,500.56 |
| 3 | Тайлант үеийн үр дүн | - | - | 185,041,747.35 | 185,041,747.35 |
| 4 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | - | - | 2,217,454,247.91 | 2,217,454,247.91 |
| 5 | 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | - | - | 2,217,454,247.91 | 2,217,454,247.91 |
| 6 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 2,217,454,247.91 | 2,217,454,247.91 |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | (250,494,559.27) | (250,494,559.27) |
| 8 | **2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **-** | **-** | **1,966,959,688.64** | **1,966,959,688.64** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

*Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан*

*/төгрөгөөр/*

| код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 1,408,846,900.00 | 1,280,653,813.07 |
| 12 | Татварын бус орлого | 1,408,846,900.00 | 1,280,653,813.07 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 414,047,500.00 | 293,742,713.07 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | - | 284,832.07 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 414,047,500.00 | 293,457,881.00 |
| 122 | Тусламжийн орлого | 994,799,400.00 | 986,911,100.00 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 994,799,400.00 | 986,911,100.00 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,606,659,400.00 | 1,448,695,775.92 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,606,659,400.00 | 1,448,695,775.92 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,606,659,400.00 | 1,448,695,775.92 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,241,410,600.00 | 1,137,074,448.29 |
| 210101 | Үндсэн цалин | 778,320,500.00 | 727,941,384.45 |
| 210102 | Нэмэгдэл | 452,097,800.00 | 398,140,763.84 |

| | | | |
|---|---|---|---|
| 210104 | Урамшуулал | 10,992,300.00 | 10,992,300.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 154,638,300.00 | 137,793,272.83 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 104,981,800.00 | 93,908,086.89 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,414,100.00 | 10,974,096.48 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,207,100.00 | 5,488,348.17 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,207,100.00 | 5,488,348.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,828,200.00 | 21,934,393.12 |
| 2105 | Нормативт зардал | 172,039,100.00 | 136,746,354.80 |
| 210502 | Хоол, хүнс | 172,039,100.00 | 136,746,354.80 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,568,600.00 | 4,162,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,568,600.00 | 4,162,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,002,800.00 | 32,919,700.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 23,474,800.00 | 23,393,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,528,000.00 | 9,526,100.00 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | (197,812,500.00) | (168,041,962.85) |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 197,812,500.00 | 168,041,962.85 |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | 197,812,500.00 | 168,041,962.85 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 210,311,701.22 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 42,269,738.37 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 12,525.7 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 12,525.7 мянган төгрөгийн алдааг залруулсан.

*Залруулсан алдаа:*

- ✓ Тайлант онд Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийгмийн даатгалын шимтгэлийг мөнгөн гүйлгээний тайлангийн нийгмийн даатгалын шимтгэлийн дүнтэй тулган шалгахад 6,294.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн нь УСНББОУС-1 "*Санхүүгийн тайлангийн толилуулга*," болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,
- ✓ Тайлант онд 6,230,746.35 төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг тайлагнаагүй нь УСНББОУС-1 "*Санхүүгийн тайлангийн толилуулга*," болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй,
- ✓ Сангийн сайдын хүчингүй болсон 2006 оны 388 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан маягтаар 2025 оны Санхүүгийн тайланг тайлагнасан нь УСНББОУС-1 "*Санхүүгийн тайлангийн толилуулга*", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалын хавсралтаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам" болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгааг залруулав.

Аудитаар 2 зөрчилд албан шаардлага, 2 зөрчилд зөвлөмжийг хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 227,524.1 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон 9,850.3 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс давсан тул "Өөрчлөлттэй" дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

### 5.1 Албан шаардлага

***Илрүүлэлт-1*:** Бараа материалын тайланг тулган баталгаажуулахад хүнсний тайлангийн 22,834.2 мянган төгрөгийн 11 ширхэг орлогын баримт, 644.6 мянган төгрөгийн 4 ширхэг зарлагын баримт тус тус дутуу байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*", 20 дугаар зүйлийн 20.1-д "*нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Анхан шатны баримтын бүрдлийг хангаагүй тайланг баталгаажуулахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

***Илрүүлэлт-2*:** Шилэн дансны мэдээллийн системд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,068,739.6 мянган төгрөгийн орлогын 35 гүйлгээ, 47,873.1 мянган төгрөгийн зарлагын 6 гүйлгээ, мөн тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "*мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх*", 4.1.3-д "*тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх*", 6 дугаар зүйлийн 6.4.5-д "*цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр*" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Шилэн дансны тухай хуулийг үнэн зөв, цаг хугацаанд бүрэн мэдээллэж ажиллах тухай албан шаардлага хүргүүлсэн.

### 5.2 Зөвлөмж

***Илрүүлэлт-1*:** Байгууллагын албан хаагчдад 30,096.9 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ыг хөтлөөгүй, байгууллагын даргын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 20 дугаар зүйлийн 20.1-д "*нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах*", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журам"-ын гуравдугаар бүлэгийн 1-д "*Төрийн албан хаагч энэ журмын хавсралтаар баталсан “Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас”-ны дагуу илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласан үндэслэл, гүйцэтгэсэн ажлын гол агуулга, нэмэгдүүлсэн цалин хөлсний тооцоог нэгжийн даргаар хянуулж баталгаажуулсны үндсэн дээр байгууллагын дарга зөвшөөрөл олгосны дараа санхүүд хүргүүлнэ*" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Илүү цагийн нэмэгдэл хөлсийг холбогдох журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж олгож байх зөвлөмж хүргүүлсэн.

***Илрүүлэлт-2*:** Байгууллагын албан хаагчдад 174,593.0 мянга төгрөгийн ээлжийн амралтын олговорыг олгохдоо ээлжийн амралт олгох тухай мэдэгдэл, ээлжийн амралтын олговор бодсон хуудас хөтлөөгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*", 20 дугаар зүйлийн 20.1-д "*нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах*", Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дүгээр тушаалаар баталсан "Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам"-ын 1.3-д "*Ажил олгогч ээлжийн амралтын хуваарийн дагуу энэхүү журмын нэгдүгээр хавсралтаар баталсан "Ээлжийн амралт олгох мэдэгдэл"-ийг байгууллагын холбогдох нэгж болон ажилтанд олгоно*", 1 дүгээр хавсралт "ээлжийн амралт олгох тухай мэдэгдэл", 2 дугаар хавсралт "ээлжийн амралтын цалингийн тооцоо" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Ээлжийн амралтын олговрыг холбогдох журмын дагуу эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж олгож байх зөвлөмж хүргүүлсэн.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | *Залруулсан* | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийгмийн даатгалын шимтгэлийг мөнгөн гүйлгээний тайлангийн нийгмийн даатгалын шимтгэлийн дүнтэй тулган шалгахад 6,294.9 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн | 1 | 6,294.9 | 1 | 6,294.9 | | | 1 | 6,294.9 | | | | |
| 6,230.7 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөгийг тайлагнаагүй | 1 | 6,230.7 | 1 | 6,230.7 | | | 1 | 6,230.7 | | | | |
| **ДҮН** | **2** | **12,525.6** | **2** | **12,525.6** | | | **2** | **12,525.6** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Тайлант онд байгууллагын албан хаагчдад 30,096.9 мянган төгрөгийн илүү цагийн нэмэгдэл хөлс олгохдоо "Нэмэгдэл хөлс тооцож олгох хуудас"-ыг хөтлөөгүй, байгууллагын даргын зөвшөөрлөөр баталгаажуулаагүй олгосон | 1 | 30,096.9 | | | | | 1 | 30,096.9 | | | | |
| Тайлант онд албан хаагчдад 174,593.0 мянган төгрөгийн ээлжийн амралтын олговорыг олгохдоо ээлжийн амралт олгох тухай мэдэгдэл, ээлжийн амралтын олговор бодсон хуудас хөтлөөгүй | 1 | 174,593.0 | | | | | 1 | 174,593.0 | | | | |
| | | | | | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Бараа материалын тайланг тулган баталгаажуулахад хүнсний тайлангийн 22,834.2 мянган төгрөгийн 11 ширхэг орлогын баримт, 644.6 мянган төгрөгийн 4 ширхэг зарлагын баримт дутуу | 1 | 22,834.2 | | | 1 | 22,834.2 | | | | | | |
| **Дүн** | **1** | **227,524.1** | | | **1** | **22,834.2** | **2** | **204,689.9** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** /мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны мэдээллийн системд 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 1,068,739.6 мянган төгрөгийн орлогын 35 гүйлгээ, 47,873.1 мянган төгрөгийн зарлагын 6 гүйлгээ, мөн тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг тус тус мэдээлээгүй | 1 | 1,116,612.6 | | | 1 | 1,116,612.6 | | |
| **Дүн** | **1** | **1,116,612.6** | | | **1** | **1,116,612.6** | | |